

19.18. Дотуур байранд амьдран суугчдын мэдээлэл импортлох

Дотуур байранд амьдран суугчдын мэдээллийг excel файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох excel – файлын загвар нь системийн **Дата импорт -> Дотуур байр-Хүний мэдээлэл -> Загвар татах -> DormitoryImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.

ДБУМС Туршилтын интерпрайз user1

Дата импорт Хаах

Мэдээллийн төрөл: Дотуур байр->Хүний мэдээлэл Загвар татах | Импорт дата | Хуулах | Устгах | Excel-рүү гаргах

Төлөв	Тайлбар	Мөр	Процесс	Байрны код	Регистрийн дугаар	Овог	Нэр	Ажилладаг эсвэл амьдардаг эсэх	Хүсэлт гаргасан огноо
✓	Хууладсан	1	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ЧП69050487	Лусандорж	Эрдэнэбаяр	Амьдран суудаг	2019-01-01 00:00:00
✓	Хууладсан	2	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ХВ79060514	Лхаажав	Баттөр	Амьдран суудаг	2019-01-02 00:00:00
✓	Хууладсан	3	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ЦЗ74091705	Батбаяр	Хулан	Амьдран суудаг	2019-01-03 00:00:00
✓	Хууладсан	4	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ХП83081415	Гомбосүрэн	Адъяабазар	Амьдран суудаг	2019-01-04 00:00:00
✓	Хууладсан	5	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	БЮ76022618	Самжид	Алтанхуяг	Ажилладаг	2019-01-05 00:00:00
✓	Хууладсан	6	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ЧП85092204	Хүрэлбаатар	Ариунсайхан	Ажилладаг	2019-01-06 00:00:00
✗	Хүний мэдээлэл олдсонгүй.	7	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ЧН80020878	Мялмартогтох	Бат-Очир	Ажилладаг	2019-01-07 00:00:00
✓	Хууладсан	8	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	УЗ85061617	Энхбат	Наймдорж	Ажилладаг	2019-01-08 00:00:00
✓	Хууладсан	9	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ХЙ81091792	Оюунцагч	Батбаатар	Ажилладаг	2019-01-08 00:00:00
✓	Хууладсан	10	2020/06/15 11:33:34 (100000041638695)	wqe	ЮД80090707	Цыденжалова	Ариуна Байрвна	Амьдран суудаг	2019-01-10 00:00:00

2018 © Бүх эрх хуулиар хамгаалагдсан. БСШУСЯ

Өмнөх нөхцөл

- Сургалтын байгууллагын төлөв нь идэвхтэй байх
- Салбар, бүрэлдэхүүн сургууль үүссэн байх, төлөв нь идэвхтэй байх
- Сургалтын нэгж үүссэн байх, төлөв нь идэвхтэй байх

Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт онсар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангиллаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

Файлын баганын мэдээлэл

Баганы нэр	Төрөл	Тайлбар	Заавал бөглөх талбар эсэх
Сургалтын байгууллагын код	Текст	Дотуур байрны харъяалагдах сургалтын байгууллагын кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын	Заавал

		мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллагыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Сургалтын байгууллагын кодыг Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код талбараас харна уу!	
Салбар, бүрэлдэхүүн сургуулийн код	Текст	Дотуур байрны харъяалагдах салбар, бүрэлдэхүүн сургуулийн кодыг оруулна. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн кодыг Систем > Манай байгууллага > Салбар, бүрэлдэхүүн сургууль > Код талбараас харна уу!	Нэмэлт
Байрны код	Текст	Дотуур байранд амьдарч буй болон амьдрахаар хүсэлт гаргасан байрны кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд дотуур байрыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор байрыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Байрны кодыг Систем > Сургалтын орчин > Барилга, байгууламж таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Байрны код талбараас харна уу!	Заавал
Регистрийн дугаар	Текст	Регистрийн дугаарын мэдээллийг үнэн зөв оруулна. Хэрэв гадаад оюутан бол бүртгэлийн дугаарыг оруулна.	Заавал
Овог	Текст	Эцэг / эхийн нэрийг оруулна.	Заавал
Нэр	Текст	Нэрийн мэдээллийг оруулна.	Заавал
Ажилладаг эсвэл амьдардаг эсэх	Сонголт	Ажилладаг эсвэл амьдардаг эсэхийг	Заавал

		сонгоно.	
Хүсэлт гаргасан огноо	Огноо	Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан огнооны мэдээллийг оруулна.	Заавал
Төлөв	Сонголт	Төлөв (хүсэлт гаргасан, идэвхтэй, идэвхгүй)-ийг сонгоно.	Заавал